



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ТУУЛЫН ХИШИГ ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Ерөнхий дүгнэлт:

Тус үйлдвэрийн газар нь хөрөнгө нөөцийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, хуримтлагдсан өр авлагыг барагдуулах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажиллаж чадахгүй байна.

Сүхбаатар сум
2016 он

<u>Тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Шинжээч Э.Эрдэнэзул 2016 оны 07 сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70363036 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны Өргөтгөлд	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Хоёр. Үндсэн мэдээлэл Гурав. Аудитын дүн 1.ОНӨААТҮГ- уудын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу? • Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу. • Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу. • Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу. 2.ОНӨААТҮГ-ууд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу? • Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу. • Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу. • Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх. 3.Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу? • Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу. • Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу. • Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу. Дөрөв. Илрүүлсэн зөрчил Тав. Аудитын дүгнэлт Зургаа. Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Саналд өгсөн тайлбар
--	---

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХАА	Хөдөө аж ахуй
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ДЭХ	Дулаан эрчим хүч
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
УХӨТ	Урт хугацаат өр төлбөр

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

1. Аудитын нэр: “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн

2. Аудитын код: СЭАГ-2016/01-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршив.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
- Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитаар 13 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2015, 2016 оны 1-4 сар хүртэлх үйл ажиллагаатай холбоотой гаргасан сумын ИТХ-ын тогтоол шийдвэрүүд, тус ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримтуудыг хамруулав.

6. Үндсэн мэдээлэл:

Орхонтуул сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 04-р сарын 24-ний өдрийн 28 тоот тогтоолоор Туулын хишиг ОНӨААТҮГ-ыг байгуулан сумын Засаг даргын 2009 оны 41 тоот захирамжаар үйлдвэрийн газрын дүрмийг баталсан байна.

Үйлдвэрийн газар нь газар тариалан, хөдөө аж ахуйн машин механизмийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэхээр 2009 оны 05 дугаар сарын 04-ний өдөр улсын бүртгэлийн 1314001011 тоот гэрчилгээ авсан байна.

Тус ОНӨААТҮГ нь 2015 онд 233414,4 мянган төгрөгийн орлого олж, 313463,8 мянган төгрөгийн зардал гарган 80049,4 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

2015 онд авлага 5947,0 мянган төгрөгөөр өсч, өглөг 59662,9 мянган төгрөгөөр буурсан бөгөөд 33210,2 мянган төгрөгийн нүүрс, шатахуун, 19249,8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал худалдан авсан байна.

2016 оны 1-4 сарын байдлаар 93764,8 мянган төгрөгийн орлого олж, 105156,4 мянган төгрөгийн зардал гарган 11391,6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

7. Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан Туулын хишиг ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогчтой ярилцлага хийн, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

8. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад ОНӨААТҮГ-ын батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгохоос гадна дараах үзүүлэлтийг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Авто тээврийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон МУ-ын Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм.

9. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, шинжээч Э.Эрдэнэзул 2015 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1

1. Туулын хишиг ОНӨААТҮГ нь жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй, сумын Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулаагүй байна.

1.1 Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.1¹ заалтыг зөрчин тусгай зөвшөөрөлгүйгээр цэвэр ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг эрхэлж байна.

Туулын хишиг ОНӨААТҮГ-ын дүрэмд дараах чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхээр заажээ. Үүнд:

- Сумын төвийн иргэд, төсвийн байгууллагуудын дулаан хангамж, тохижилт, түүний орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарим засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх, хяналт тавих
- Сумын төв, хөдөөд газар тариалан эрхлэх, дулаан цэвэр ус хэрэглэх үйл ажиллагаа явуулах иргэн, байгууллагатай гэрээ хийх, ашиглалтын төлбөр тооцоог хийх
- Орон нутгийн өмчийн ХАА-н техник хэрэглэлийг эрх бүхий байгууллагын тогтоосон чиглэл, хуваарь, үнэ тарифаар үйлчилгээ эрхлэх
- Орон нутгийн өмчийн техник бусад хэрэгслээр төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг мөн тогтоосон үнэ тарифаар үзүүлэх гэж тус тус заажээ.

Сэлэнгэ аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийг 2014 оны 04-р сарын 15-ны өдрөөс 5 жилийн хугацаатай олгосон байна.

Үйлдвэрийн газар нь дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үндсэн үйл ажиллагааны чиглэлийг улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19.1¹-р зүйлд заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн албаны дарга П.Эрдэнэсайхан үйлдвэрийн газрын дарга Л.Гантулга нарын хооронд 2014 оны 04-р сарын 01-ний өдөр 1 жилийн хугацаатай орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйлдвэрлэл үйлчилгээ борлуулалтын үр ашгийг дээшлүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй

¹ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулах, эрх үүрэг хариуцлагыг тодорхойлох зорилготой гэрээ байгуулсан байна.

Дээрх гэрээний 2.7-д *“Захирал тайлант жилийн үйл ажиллагааны талаарх ажлын тайлангаа Орон нутгийн өмчийн албанд өгснөөс хойш 1 сарын дотор гэрээний биелэлтийг дүгнэнэ”* гэж заасан боловч 2015 онд уг гэрээг дүгнээгүй байна.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.1²- д заасан холбогдох тусгай зөвшөөрөлгүйгээр цэвэр ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг эрхэлж байна.

1.2 Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй, сумын Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулж мөрдөн ажиллаагүй байна.

Орхонтуул сумын Засаг даргын 2009 оны 04-р сарын 08-ны өдрийн 41 тоот захирамжаар батлагдсан үйлдвэрийн газрын дүрмийн 6.3-д *“Газрын дарга нь Орхонтуул сумын Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулж мөрдөн ажиллана”*, 7.2-д *“Газрын бизнес төлөвлөгөө, цалингийн сан, урамшууллын хэлбэр, зардал, орлого ашгийг төлөвлөж гэрээнд тусган баталгаажуулна”* 7.3-д *“жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хариуцна”* гэж заасан боловч тус үйлдвэрийн газрын дарга Л.Гантулга нь сумын Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулаагүй, үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулж ажиллаагүй байгаа нь үйлдвэрийн газрын дүрмийн дээрх заалтууд болон МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20³.3⁴ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Үйлдвэрийн газрын дүрмийн 5.3.в-д *“Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан баланс, мэдээ тайланг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх үйл ажиллагааныхаа тайланг сумын ИТХТ, Засаг даргад жил бүр тайлагнах”* гэж заасны дагуу Орхонтуул сумын ИТХ-ын 2016 оны 04-р сарын 11-ний өдрийн 89 тоот тогтоолоор үйлдвэрийн газрын 2015 оны үйл ажиллагааг *“хангалттай”* гэж дүгнэсэн байгаа нь сүүлийн 3 жил алдагдалтай ажиллаж, их хэмжээний хуримтлагдсан өр, авлагатай байхад бодит байдалтай нийцээгүй үнэлэлт дүгнэлт болсон байна.

1.3 Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах дотоод хяналт хангалтгүй байна.

² Хот, суурины усан хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

³ Захирлын эд хөрөнгийн эрх үүрэг

⁴ Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

Тус үйлдвэрийн газрын 2015 оны санхүү, үндсэн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Бүх ажиллагсдын 2016 оны 03-р сарын 24-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн баталсан дотоод журмын 2.7-д **“Үйлдвэрийн газар нь дотоод хяналтын зөвлөлтэй байна. Энэхүү зөвлөл нь 4 хүний бүрэлдэхүүнтэй байна. Бүрэлдэхүүнийг хамт олны хуралдаанаар томилно”** гэж заасан боловч дотоод хяналтын зөвлөлийг томилоогүй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2016 оны 05-р сарын 02-ны өдөр баталсан 18-03-002/47 тоот удирдамжийн дагуу тус үйлдвэрийн газарт байгаль орчин, эрчим хүч, эрүүл ахуй халдвар хамгаалал, барилгын техникийн хяналтын улсын байцаагчид хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд орсон ажлуудыг хугацаанд нь хийдэггүй, хөрс агаарын шинжилгээг тогтмол хийлгэдэггүй, дүгнэлтээр гарсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ аваагүй, ус ашиглах дүгнэлт, гэрээгүй, ус авах цэгт тоолуур байршуулаагүй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, журам батлуулан мөрдөж ажиллаагүй, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Аймгийн Аудитын газраас хийж гүйцэтгэсэн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгөгдснөөс хувь хүнээс өндөр хүүтэй мөнгө зээлж, хүүгийн үр ашиггүй зардал гаргах явдлыг зогсоох зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 2015 онд хувь хүнээс арилжааны банкнаас өндөр хүүтэй /сарын 10-15 хувь/ мөнгө зээлж 531,4 мянган төгрөгийн хүүгийн үргүй зардал гаргасан байна.

БҮЛЭГ 2

Тус үйлдвэрийн газар нь санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, мөрдөн ажиллаагүй, орлогыг бүрэн төвлөрүүлэх, хөрөнгө нөөцийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, хуримтлагдсан өр авлагыг барагдуулах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүйгээс алдагдалтай ажилласан байна.

2.1 Түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Орхонтуул сумын Засаг даргын 2009 оны 41 тоот захирамжаар батлагдсан Туулын хишиг ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.3 –дах “Газрын дарга нь Орхонтуул сумын Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулж мөрдөн ажиллана”, 7.2-дах “Газрын бизнес төлөвлөгөө, цалингийн сан, урамшууллын хэлбэр, зардал, орлого ашгийг төлөвлөж гэрээнд тусган баталгаажуулна”, 7.3-дах “жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хариуцна” гэсэн заалтууд болон 2014 оны 04-р сард Орон нутгийн өмчийн албатай байгуулсан гэрээний 3.8-д **“Захирал нь үйлдвэрийн газрын бизнес төлөвлөгөөг орон нутгийн өмчийн албаар батлуулан, биелэлтийг**

ханган ажиллана” гэж заасан боловч үйлдвэрийн газар нь санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулсан, мөрдөж ажиллаагүй байна.

Тус газрын 2015 он, 2016 оны 1-4 сарын байдлаарх орлогын гүйцэтгэлийг авч үзвэл:

/Хүснэгт №1 мян. төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2015 он	2016 оны 1-4 сар
1	Дулаан эрчим хүч, цэвэр усны борлуулалтын орлого	155499,0	93764,8
2	Түрээсийн орлого /газар тариалан /	66363,6	-
3	техник тоног төхөөрөмжөөр үйлчилсний орлого	3520,9	-
	Нийт орлого	225383,5	93764,8

2015 онд дулаан эрчим хүч, цэвэр усны борлуулалтаас 155499,0 мянган төгрөг, газрын түрээс, техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээний 69884,5 мянган төгрөг зэрэг нийт 225383,5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн бол Сэлэнгэ аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2015 оны 12-р сарын 28-ний өдрийн 32 тоот тогтоолоор 2016 оны 01-р сарын 01-ний өдрөөс орон сууцны халаалтын тарифыг 351,8 төгрөгөөр /НӨАТ-гүй дүн/ тогтоож, 2016 оны 4-р сарын байдлаар дулаан эрчим хүч, цэвэр усны борлуулалтаас 93764,8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №2/

Эрчим хүчний зөвлөлийн тогтоол	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
2013.06.14	Үйлдвэр ААН байгууллагын халаалт	Төг/ м3	926
	Орон сууцны халаалт	Төг/м2	239
	Үйлдвэр ААН байгууллагын халаалт	Төг/ м3	926
2015.12.28	Орон сууцны халаалт	Төг/м2	351,8

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь “Сэлэнгэ тариа” ХХК-тай 2015 оны 02-р сарын 25-ны өдөр 01 тоот “Газар ашиглуулах” гэрээ байгуулж, өөрийн 363,88 га талбайг 5 жилийн хугацаанд ашиглуулан, 2015 оны 2-р сарын 27-ны өдрийн дотор түрээсийн төлбөрийн 100000,0 мянган төгрөгийг, 2015 оны 12-р сарын 01-ний өдрийн дотор 54000,0 мянган төгрөгийг авахаар гэрээнд тусгаж, тус онд 66363,6 /НӨАТ-гүй/ мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлсэн ба санхүүгийн тайланд түрээсийн орлогыг гэрээний дүнгээр тусгаагүйгээс, 73636,4 мянган төгрөгийн /НӨАТ-гүй/ орлогыг дутуу тусгасан байгаа нь *МУ-ын Сангийн сайдын 2012 оны 03-р сарын 28-ны өдрийн 77 дугаар тушаалын 1-р хавсралтын дагуу 3-р зүйлд “аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар бэлтгэх”, “аккрузл суурь” гэж мөнгө хүлээн авсан эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

2015 онд төлөгдөх ёстой нийт 154000,0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрөөс түрээслэгч “Сэлэнгэ тариа” ХХК нь 73000,0 мянган төгрөгийг төлсөн ба үлдэгдэл 81000,0 мянган төгрөгийг ургац алдсан гэх шалтгааны улмаас төлөөгүй байгаа нь гэрээний 4.2 дэх “Түрээслэгч нь энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу түрээсийн

төлбөрийг тогтсон хэмжээгээр хугацаанд нь төлөх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Хувь хүнээс өндөр хүүтэй зээл авч хүүгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2015 онд дулааны эрчим хүч, цэвэр усны борлуулалтаас 155499,0 мянган төгрөг, газрын түрээс, газар тариалангийн үйлдвэрлэлд техникээр үйлчилгээ үзүүлсний 69884,5 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 8000,0 мянган төгрөг, бусад 30,8 мянган төгрөгийн зэрэг нийт 233414,3 мянган төгрөгийн орлого олж, 313463,8 мянган төгрөгийн зардал гарган **80049,5** мянган төгрөгийн алдагдалтай, 2016 оны 4-р сарын байдлаар 93764,8 мянган төгрөгийн орлого олж, 105156,4 мянган төгрөгийн зардал гарган **11391,6** мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №3 мян.төгрөг/

№		2015 он	2016 оны 1-4 сар
1	Түгээсэн дулаан эрчим хүч, цэвэр усны орлого	155499,0	93764,8
2	Түрээсийн орлого	69884,5	-
3	Бусад орлого	8030,8	-
	Нийт орлого	233414,3	93764,8
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	62026,3	27910,7
2	НДШ	8724,0	3523,3
3	Цахилгаан	25564,7	15511,7
4	Томилолтын зардал	480,8	100,7
5	Шатахууны зардал	5939,3	3127,7
6	Нүүрс	58044,5	18150,5
7	Сэлбэг, Хангамжийн материал	28474,9	1956,2
8	Шуудан холбоо	600,0	185,0
9	Мэргэжлийн үйлчилгээ	3000,0	-
10	Элэгдэлийн зардал	77160,4	30018,2
11	Тээврийн зардал	36023,7	1222,9
12	Татвар, Торгууль, шимтгэл хураамж	1563,7	99,5
13	Хүүгийн зардал	2496,6	-
14	Бусад зардал	3364,9	3350,0
	Нийт зардал	313463,8	105156,4
	Ашиг, алдагдал	(80049,5)	(11391,6)

Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2015 оны үйлдвэрлэлийн зардлын 14,1 хувийг цалингийн зардал, 2,1 хувийг НДШ-ийн зардал, 9,4 хувийг цахилгааны зардал, 1,2 хувийг шатахууны зардал, 21,2 хувийг нүүрсний зардал, 10,2 хувийг сэлбэг хангамжийн материалын зардал, 28,2 хувийг элэгдэлийн зардал, 13,2 хувийг тээврийн зардал, 0,4 хувийг бусад зардал эзэлж байгаа бол удирдлагын зардлын 58,3 хувийг цалингийн зардал, 7,4 хувийг НДШ-ийн зардал, 1,2 хувийг томилолтын зардал, 6,4 хувийг шатахууны зардал, 1,8 хувийг сэлбэг, хангамжийн материалын зардал, 1,5 хувийг шуудан холбооны зардал, 7,5 хувийг мэргэжлийн үйлчилгээний зардал, 3,9 хувийг татвар, торгууль шимтгэлийн зардал, 6,2 хувийг зээлийн хүүгийн зардал, 5,8 хувийг бусад зардал эзэлж байна.

2014, 2015 онуудад иргэдээс арилжааны банкны зээлийн хүүнээс өндөр /сарын 10-15 хувь/ хүүтэй зээл гэрээ байгуулан авсан байна. Жишээлбэл 2014 онд 2 иргэнээс 6986,0 мянган төгрөгийн, 2015 онд 4 иргэнээс 6014,0 мянган төгрөгийн зээл тус тус авч 2015 онд зээлийн хүүгийн зардалд 2496,6 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргажээ.


2015 оны 10-р сард аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон 8000,0 мянган төгрөгийн дэмжлэгээс үйлдвэрийн газрын дарга Л.Гантулга нь 7600,0 мянган төгрөгийг өөрийн харилцах данс руу шилжүүлэн авч БНХАУ-ын Эрээн хотоос 8 нэр төрлийн 7167,0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, Дарсан тек ХХК-аас 433,0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулсан байна. Цаашид худалдан авалтыг үйлдвэрийн удирдлага бус нярав, инженер гүйцэтгэж байх шаардлагатай байна.

ОНӨААТҮГ нь 2015 онд хэрэглэх нийт нүүрсний хэрэглээгээ 2014 оны намар татаж бэлтгэн зарцуулж байгаа боловч, нүүрсний зарцуулалтыг тодорхой хэмжих нэгжгүйгээр “**тэрэг**”-ний рейсийн тоогоор тооцож байна. Иймд цаашид уурын зуухны хүчин чадал, өдөрт зарцуулах нүүрсний норм, нормативыг нарийн тогтоон мөрдөж, ажиллах нь зүйтэй юм.

2.3 Хуримтлагдсан өглөг, авлагыг барагдуулах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Үйлдвэрийн газар нь 2015 оны эхэнд 46514,4 мянган төгрөгийн авлага, 252133,7 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан бол 2015 онд авлага 12,8 хувиар өсч, өр төлбөр 23,7 хувиар буурсан байна.Хүснэгтээр харуулбал:

/График №1 мян. төгрөг/



2015 оны авлагыг задлан харуулбал:

/Хүснэгт №5 мян.төгрөг/

№	Үзүүлэлт	2014 он	2015 он
1	Дансны авлага	28768,1	28768,1
2	12 жилийн сургууль	10197,7	16841,4
3	Цэцэрлэг	2115,5	3108,5
4	Цагдаагийн байр	2102,1	641,7
5	Айл өрхөөс авах авлага	3330,9	3101,7
	Нийт	46514,4	52461,4

2015 оны эхэнд Орхонтуул сумын 12 жилийн сургуулиас халаалт цэвэр усны 10197,7 мянган төгрөгийн, цэцэрлэгээс 2115,5 мянган төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 7636,7 мянган төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 19949,9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Тус авлагыг барагдуулахаар аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс, төсвийн байгууллагын захирал, эрхлэгч нарт хандан удаа дараа албан тоот явуулсан боловч төсөв хүндэрч, санхүүжилт дутуу орж ирсэн гэсэн шалтгаанаар авлагыг бүрэн барагдуулаагүй байна.

Хэдэн онд үүссэн, хэнээс авах, хэнд төлөх нь тодорхой бус 28768,1 мянган төгрөгийн дансны авлага, 17402,1 мянган төгрөгийн дансны өглөг санхүүгийн тайланд тусгагдсан байгаа нь хөрөнгө эзэнгүйдэх, компаний мөнгөн хөрөнгийн эргэлт саарах улмаар эргэлтийн хөрөнгө дутагдах нөхцөл байдлыг үүсгэж байна. Иймд эзэн холбогдогчийг олж тогтоон авлага, өглөгийг барагдуулах шаардлагатай юм.

Үйлдвэрийн газар нь 2014 оны жилийн эцэст 252133,7 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан ба 2015 онд 23,6 хувиар буурч 192470,8 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан байна. Хүснэгтээр харуулбал:

2014, 2015 оны өглөгийг задлан харуулбал:


/Хүснэгт №6 мян.төгрөг/

№	Үзүүлэлт	2014 он	2015 он
1	Дансны өглөг	110010,3	96036,3
1.1	Уулс заамар-1	9008,0	9008,0
1.2	ТЭДС	69626,2	69626,2
1.3	Агромаштех	13974,0	-
1.4	Зуухны үнэ	2680,0	2680,0
1.5	Тодорхойгүй	14722,1	14722,1
2	Хувь хүнд өгөх өглөг	9822,3	1431,7
2.1	Цэрэннадмид	4800,0	-
2.2	Цэвэгбаатар	210,0	-
2.3	Даваадорж	3135,3	-
2.4	Отгонбат	1677,0	431,7
2.5	Саранжавхаа	-	1000,0
3	Ажиллагсадтай холбоотой тооцоо	-	1020,0
4	Байгууллагад өгөх өглөг	500,0	585,0
5	Татварын өглөг	33934,9	24952,0
5.1	НӨАТ-ын өр	25404,6	13450,3
5.2	ХХОАТ-ын өр	8530,3	11501,7
6	Бусад БХӨТ	79289,0	60659,2
6.1	Тахилт зул ХХК /Нүүрс/	77803,9	9372,0
6.2	Шивээ овоо ХХК /Нүүрс/	-	47657,2
6.3	Шатахууны өглөг	1485,1	-
6.4	Цахилгааны өглөг	-	3630,0
7	НДШ өглөг	7410,5	7225,6
8	УХӨТ	10266,7	-
	Нийт	251233,8	191909,8

2014 оны жилийн эцэст НӨАТ-ын 25404,6 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 8530,3 мянган төгрөгийн, бусад БХӨТ /нүүрс, шатахуун/ 79289,0 мянган төгрөгийн, НДШ-ийн 7410,5 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан бол 2015 оны эцэст НӨАТ-ын өр 11954,3 мянган төгрөгөөр, НДШ-ийн өр 184,9 мянган төгрөгөөр, бусад БХӨТ 22259,8

мянган төгрөгөөр тус тус буурч, ХХОАТ-ын өр 2971,4 мянган төгрөгөөр өссөн байна. 2015 оны өглөгийг бүтцээр нь харуулбал:

/График №2/



Тус үйлдвэрийн газар нь Хүнс хөдөө аж ахуйн яамны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих санд 2014 оны 12-р сарын 31-ний өдрийн тооцоо нийлсэн актаар 69626,2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн өртэй байсан бөгөөд ТЭДС-ийн зүгээс хугацаа хэтэрсэн өр дээр 34813,1 мянган төгрөгийн алданги тооцож 104439,3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Шүүхийн шийдвэрээр 81000,0 мянган төгрөгийн төлбөр төлөхөөр шийдвэрлэгдэж тус төлбөрөөс Цагааннуур сумын “Шинэ нуур” ХХК-д Беларус 1221 дугуйт трактор 2 ширхэг, ОПС 2,1 үрлүүр 3 ширхэг, лидер 4 сийрүүлэгч-1 ширхэг, ПНЛ 5-35 анжис-1 ширхэг техникүүдийг төлбөрийн 72000,0 мянган төгрөгөнд тооцон 2016 оны 05-р сарын 13-нд акт үйлдэн хүлээлгэн өгч, үлдэгдэл төлбөр 9000,0 мянган төгрөгийг үл маргах журмаар төлж барагдуулахаар тохирчээ. “Уулс заамар” ХХК-тай 2013 оны жилийн эцсийн тооцоо нийлсэн актаар баталгаажсан 9008,0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан нь өнөөг хүртэл төлөгдөөгүй байна.

Хувь хүнд өгөх өглөгийг задлан харуулбал:

№	Үзүүлэлт	2015 оны эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	2015 оны эцсийн үлдэгдэл
1	Цэрэннадмид	4800,0	800,0	5600,0	-
2	Цэвэгбаатар	210,0	-	210,0	-
3	Даваадорж	3135,3		3135,3	-
4	Отгонбат	1677,0		1245,3	431,7
5	Саранжавхаа	-	1000,0	-	1000,0
6	Ариунзаяа	-	1080,0	1080,0	
7	Отгонцэцэг	-	3464,7	3464,7	-
8	Гүндэгмаа		1150,0	1150,0	-
9	Жаргалсайхан		250,0	250,0	-
10	Эрдэнэчулуун		31,4	31,4	-
	НИИТ	9822,3	7776,1	16166,7	1431,7

2014, 2015 онуудад иргэдээс арилжааны банкны зээлийн хүүнээс өндөр /сарын 10-15 хувь/ хүүтэй зээл гэрээ байгуулан авсан байна. Жишээлбэл 2014 онд 2 иргэнээс 6986,0 мянган төгрөгийн зээл авч зээлийн хүүнд 1898,6 мянган төгрөг, 2015 онд 4 иргэнээс 6014,0 мянган төгрөгийн зээл авч зээлийн хүүнд 531,4 мянган төгрөг зэрэг нийт 2430,0 мянган төгрөгийг зээлийн хүүгийн зардалд төлж хүүгийн үр ашиггүй зардал гаргасан байна. Хүснэгтээр харуулбал:

/ 2014-2015 онд иргэдээс хүүтэй авсан зээл болон төлсөн мөнгөн дүн/

№	Зээлийн гэрээний огноо	Сарын хүү	Зээлдүүлэгчийн нэр	Авсан зээлийн хэмжээ	Зээлийн хүүнд төлсөн дүн	Нийт төлсөн төлбөр
	2013, 2014 онд авсан зээл					
1	2014.11.25	10 %	Цэрэннадмид	4000,0	1600,0	5600,0
3	2014.12.30	10 %	Ш.Отгонцэцэг	2986,0	298,6	3284,6
	НИЙТ			6986,0	1898,6	8884,6
	2015 онд авсан зээл					
1	2015.01.06	10 %	Ш.Отгонцэцэг	3014,0	301,4	3315,4
2	2015.11.14	15%	Гүндэгмаа	1000,0	150,0	1150,0
3	2015.06.04	30 %	Ариунзаяа	1000,0	80,0	1080,0
4			Саранжавхаа	1000,0	-	-
	НИЙТ			6014,0	531,4	5545,4

2013 онд Төрийн банкнаас авсан 2400,0 мянган төгрөгийн зээлийн төлбөрт 2015 онд 1245,3 мянган төгрөгийг, 2016 оны 4-р сарын байдлаар 194,0 мянган төгрөгийг, мөн Төрийн банкнаас 2012 оны 08 сарын 03-нд 3 жилийн хугацаатай авсан, 30000,0 мянган төгрөгийн зээлийн үндсэн төлбөрт 2015 онд 10266,8 мянган төгрөг, зээлийн хүүнд 1015,9 мянган төгрөгийг тус тус төлж барагдуулсан байгаа нь МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.17 “Орон нутгийн өмчит, орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн ИТХ-аас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана”, 21.5.20 “энэ хуулийн 16, 17-д заасан зөвшөөрөлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь зээл авах, үнэт цаас гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитын явцад МУ-ын Сангийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Загвар шинэчлэн батлах тухай” 277 тоот тушаалаар ААНБ-ын “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн заавар”-ын дагуу “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд шинжилгээ хийлээ.

/Хүснэгт №7/

Д/д	Шинжилгээний төрөл	2013 он	2014 он	2015 он
1.Төлбөрийн чадварын шинжилгээ				
1.1	Цэвэр эргэлтийн хөрөнгө	(152,038,965)	(126,773,669)	(119,234,838)
1.2	Хурдан хөрвөх хөрөнгийн харьцаа	0.0009	0.01	0.00
1.3	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	0.24	0.20	0.28
1.4	Эргэлтийн харьцаа	0.23	0.48	0.38
1.5	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.11	0.25	0.19
1.6	Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	(0.35)	(0.28)	(0.31)
1.7	Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин		0.28	0.36
2.Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ				
2.1	Бие даалтын коэффициент	0.49	0.44	0.50
2.2	Санхүүгийн хамаарлын коэффициент	2.04	2.26	2.01
2.3	Зохицуулалтын коэффициент	(0.63)	(0.63)	(0.62)
2.4	Өр төлбөрийн хувийн жин	51%	56%	50%
2.5	Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа	0.10	0.05	0.00
2.6	Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	1.04	1.26	1.01
3.Ашигт ажиллагааны шинжилгээ				
3.1	Борлуулалтын ашигт ажиллагааны шинжилгээ	(0.46)	(0.15)	(0.36)
3.2	Хөрөнгийн ашигт ажиллагааны шинжилгээ	(0.15)	(0.06)	(0.18)
3.3	Эздийн өмчийн ашигт ажиллагааны шинжилгээ	(0.31)	(0.13)	(0.42)

Хүснэгтээс харахад цэвэр эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадваргүй, хурдан хөрвөх хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрийн 0,09-3 хувь, түргэн хөрвөх хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрийн 20-28 хувь, **эргэлтийн хөрөнгөөрөө БХӨТ-өө төлөх чадвар муу**, 2014 онд нийт өр төлбөрийн 28 хувь, 2015 онд 36 хувь нь хугацаа хэтэрсэн нь төлбөрийн чадвар муу үзүүлэлттэйг харуулж байна. Мөн өөрийн хөрөнгөөр бие даан үйл ажиллагаа явуулах чадвар 44-50 хувь, **нийт хөрөнгөд эзлэх өр төлбөрийн хувийн жин 50-56 хувь эзэлж байгаа нь санхүүгийн тогтворгүй байдал үүссэн** байгааг харуулж байгаа бөгөөд 2013 онд (65546,5) мянган төгрөг, 2014 онд (26422,8) мянган төгрөг, 2015 онд (80049,4) мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сөрөг үзүүлэлттэй гарсан байгаа нь үйлдвэрийн газар нь санхүүгийн үзүүлэлтийн хувьд төлбөрийн чадваргүй, санхүүгийн тогтворгүй байдал үүссэн, цаашид **бие даан үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалд хүрсэн байна**.

Тус үйлдвэрийн газар нь санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, мөрдөн ажиллаагүй, орлогыг бүрэн төвлөрүүлэх, хөрөнгө нөөцийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, хуримтлагдсан өр авлагыг барагдуулах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүйгээс алдагдалтай ажиллаж байна.

БҮЛЭГ 3

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

3.1 Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1 дэх “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн 2 дах “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа, ажил 10,0 сая төгрөг*” гэсэн заалтуудыг зөрчин 2015 онд 27271,7 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг харьцуулалтын арга хэрэглэлгүй, шууд гэрээ байгуулан “Шивээ овоо” ХХК-аас худалдан авсан байна.

Тус үйлдвэрийн газар нь 2015 онд 5939,3 мянган төгрөгийн шатахуун, 632,6 мянган төгрөгийн хүнсний материал, 3906,7 мянган төгрөгийн хангамжийн материал, 14709,7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна.

3.2 Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагад үндэслэн бэлтгэсэн байна.

Үйлдвэрийн газрын 2015 он, 2016 оны 1-4 сарын бараа материалын худалдан авалт зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

/2015 он/

№	Бараа материал	Эхний үлдэгдэл	Худалдан авсан	Зарцуулсан	Эцсийн үлдэгдэл
1	Нүүрс	54422,0	27271,7	65126,5	16576,2
2	Хангамжийн материал	10419,7	3906,7	10836,6	3489,8
3	Сэлбэг, хэрэгсэл	2343,0	14709,7	17052,7	-
4	Шатахуун	-	5939,3	5939,3	-
5	Хүнсний материал	17,5	632,6	585,6	64,5
	НИЙТ	67202,2	52460,0	99531,7	20130,5

/2016 он 1-4 сар/

№	Бараа материал	Эхний үлдэгдэл	Худалдан авсан	Зарцуулсан	Эцсийн үлдэгдэл
1	Нүүрс	16576,2	1574,3	18150,5	-
2	Хангамжийн материал	3489,8	272,7	358,1	3404,4
3	Сэлбэг, хэрэгсэл	-	1259,5	1259,5	-
4	Шатахуун	-	3127,7	3127,7	-
5	Хүнсний материал	64,5	274,1	338,6	-
	НИЙТ	20130,5	6508,3	23234,4	3404,4

Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2015 оны эхэнд 67202,2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 52460,0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 99531,7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан 20130,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 2016 оны 4-р сарын байдлаар 6508,3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 23234,4 мянган төгрөгийн бараа материал зарцуулан 3404,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Бараа материалын 2015 оны эцсийн үлдэгдэл нийт дүнгээр өмнөх оноос 47071,8 мянган төгрөгөөр буюу 70,0 хувиар буурсан байна.

Үйлдвэрийн газрын гол түүхий эд материал нүүрсний худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн хэмжээг хүснэгтээр харуулбал:

/ 2015 он, тонн нүүрс/

сар	эхний үлдэгдэл	орлого	зарлага	эцсийн үлдэгдэл
1	800		338.7	461.3
2	461.3		263.95	197.35
3	197.35		122.1	75.25
4	75.25		35.1	40.15
10	40.15		28.81	11.34
11	11.34	1126	197.5	939.84
12	939.84		255.75	684.09
	НИЙТ	1126	1241.91	

/2016 он 1-4 сар, тонн нүүрс/

сар	эхний үлдэгдэл	орлого	зарлага	эцсийн үлдэгдэл
1	684.09		247.5	436.59
2	436.59		115.5	321.09
3	321.09	65	241.1	144.99
4	144.99		145.3	-
НИЙТ		65	749.4	

ОНӨААТҮГ нь хөдөлмөрийн нөхцөл, ажлыг хөнгөвчлөх бодлого баримтлан ажиллаж 2014 оны намар бүтэн халаалтын жилийн нүүрсний хэрэглээ 1185 тн нүүрсийг бэлтгэн зарцуулж, 2015 оны намар 1126 тн нүүрсийг худалдан авч зарцуулан 2016 оны 4-р сарын байдлаар нүүрсний үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

3.3 Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.

Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2015 оны эхэнд 60003,2 мянган төгрөгийн барилга байгууламж, 128415,3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 333364,9 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1350,0 мянган төгрөгийн тавилга эд хогшилтой байсан бол тайлант хугацаанд сумын ЗДТГ-ын 2014 оны 12-р сарын 25-ны өдрийн А/23 тоот тушаалаар сумын ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлсэн 50000,0 мянган төгрөгийн өртөгтэй дулааны шугам хоолойг орлогод авч, МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3⁵-дах заалтыг зөрчин ИТХ-ын тушаал шийдвэргүйгээр Агромаштех ХХК-с зээлээр худалдан авсан 13974,0 мянган төгрөгийн өртөгтэй лидер-4 маркийн сийрүүлүүрийг тус ХХК-д буцаан шилжүүлсэн байна.

Үйлдвэрийн газрын даргын 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн 20 дугаар тушаалаар батлагдсан тооллогын комисс 2015 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийж баталгаажуулсан байна.

2010 оны 11-р сарын 12-нд ашиглалтад орсон Nissan blue bird маркийн 7500,0 мянган төгрөгийн суудлын автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь иргэн Б.Болормаагийн нэр дээр бүртгэгдсэн байгаа МУ-ын Авто тээврийн тухай хуулийн 17¹-р зүйлийн 17^{1.1} дэх заалт *“Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

⁵ Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Хийж гүйцэтгэсэн аудитаар дараах зөрчлүүдэд акт, албан шаардлага бичигдлээ.

1.Төлбөрийн акт:

- Түрээсийн орлогын дутууг нөхөн төвлөрүүлэх **81000,0** мянган төгрөг

2. Албан шаардлага:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 28768,1 мянган төгрөгийн авлагыг баталгаажуулах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэн барагдуулах,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 17402,1 мянган төгрөгийн өглөгийг баталгаажуулах,
- Хувь хүний нэр дээр бүртгэгдсэн 7500,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг үйлдвэрийн газрын эзэмшилд шилжүүлэх
- Холбогдох ИТХ-ын зөвшөөрөлгүйгээр хувь хүмүүсээс 2015 онд авсан зээл -6014,0 мянган төгрөг,
- Нүүрсний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй -27271,2 мянган төгрөг зэрэг нийт **86955,4** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдлээ.

ТАВ. ДҮГНЭЛТ

Тус үйлдвэрийн газар нь хөрөнгө нөөцийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, хуримтлагдсан өр авлагыг барагдуулах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажиллаж чадахгүй байна.

- ✓ Үйлдвэрийн газрын жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлээгүй байна.
- ✓ Сумын Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулж, үр дүнг үнэлүүлээгүй байна.
- ✓ Байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулаагүй байна.
- ✓ Хуримтлагдсан өглөг, авлагыг барагдуулах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.
- ✓ Түрээсийн орлогыг дутуу бүртгэж, бүрэн төвлөрүүлээгүй байна.

- ✓ Нүүрсний худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.
- ✓ Хувь хүнээс өндөр хүүтэй зээл авч үр ашиггүй зардал гаргасан байна.

ЗУРГАА. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Орхонтуул сумын ИТХ, Засаг дарга нарт:

- ✓ Үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, үнэлэлт дүгнэлт өгч байх,
- ✓ Үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг авч хэлэлцэн, төсөв, төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан баталж байх,
- ✓ Төсөвт байгууллагуудын халаалтын өрийг барагдуулах талаар холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх

Туулын хишиг ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч нарт:

- ✓ Сумын Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулан жил бүр дүгнүүлж ажиллах
- ✓ Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулан, мөрдөж ажиллах
- ✓ Дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үндсэн үйл ажиллагааны чиглэлийг улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмж бүртгүүлэх
- ✓ Цэвэр ус дамжуулах, түгээх тусгай зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах
- ✓ Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах комиссыг томилж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах
- ✓ Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулах
- ✓ Үйлдвэрийн газрын удирдлага худалдан авалтыг гүйцэтгэдэг үйлдлийг таслан зогсоох
- ✓ Хувь хүнээс өндөр хүүтэй зээл авахгүй байх
- ✓ Хувь хүний нэр дээрх автомашиныг үйлдвэрийн газрын нэр дээр бүртгүүлэх

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

ШИНЖЭЭЧ

Э.ЭРДЭНЭЗУЛ